Хугацаат цэргийн албан хаагчдын төрөлх өвөрмөц чанарыг бие бялдрын зарим үзүүлэлт, стрессийн түвшинтэй уялдуулан судалсан үр дүн

Б.Лодойсамбуу[1], Э.Дэлгэрэхзаяа[1], Б.Батбаатар[4], Х.Цэрэнвандан[5], Д.Цэнд-Аюуш[1], С.Цэндсүрэн[2], С.Доржбат[3]

[1]АШУҮИС, МАУОУС, Монгол анагаах ухаан судлалын тэнхим
[2]АШУҮИС, ТСБЗГ, Эрдмийн сургууль
[3]АШУҮИС, Монгол Уламжлалт Анагаах Ухааны Хүрээлэн
[4]Цэргийн төв эмнэлэг
[5]АШУҮИС, Био Анагаахын Сургууль
Цахим шуудан: Lodoisambuu@mnums.edu.mn, Утас: 95697363

Түлхүүр үг:

Хувь хүний төрөлх өвөрмөц чанар (ХХТӨЧ)
Хугацаат цэргийн албан хаагч (ХЦАХ)
Хий
Шар
Бадган

Товч утга:

Үндэслэл: Уламжлалт анагаах ухааны хий шар, бадганы онол нь хүний бие, хэл, сэтгэлийг нэгдмэл байдлаар тайлбарладаг бөгөөд бие махбод эрүүл орших, өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчлөх, өвчнийг оношлох, эмчлэх аргыг онол арга зүйн хүрээнд цогц байдлаар авч үзэх үндэслэл болдог[1]. Өөрөөр хэлбэл хувь хүний эрүүл мэндийн системийг тогтолцоогоор авч үзэх, хүн бүрд нийцүүлэн оношилгоо эмчилгээний цогц нэгдмэл байдлыг хангахаар ажиллаж байгаа юм[3]. Монгол улсын тогтвортой хөгжил-2030 бодлогод Монгол хүний дундаж наслалтыг уртасгах төрийн бодлогын хүрээнд ялангуяа Монгол эрэгтэйчүүдийн дундаж наслалтыг нэмэгдүүлэх үндэсний бодлогын хүрээнд бид харьцангуй эрүүл цэргийн насны эрэгтэйчүүдийн дунд хувь хүний төрөлх өвөрмөц чанарыг тодорхойлох нь цаашид нийгмийн хариуцлагын хүрээнд Монгол эрэгтэйчүүдийн дундаж наслалтыг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой зэрэг нь энэхүү судалгааг хийх үндэслэл боллоо. **Зорилго:** Хугацаат цэргийн албан хаагчдын төрөлх өвөрмөц чанарыг сэтгэл зүйн онцлогтой харьцуулан судлах. **Арга, аргачлал:** Бид энэхүү судалгааг АШУҮИС, Монгол анагаах ухааны олон улсын сургууль, Зэвсэгт хүчний дугаар ангийг түшиглэн нэг агшингийн болон эмнэлзүйн ажиглалтын загвараар хийж гүйцэтгэсэн. Судалгааны ажлын үр дүнгийн тоон мэдээллийг боловсруулахдаа Microsoft Excel, SPSS26.0 (IBM software, Inc. USA) программуудыг ашиглан, дундаж утга, стандарт хазайлт, стандарт үзүүлэлтүүдийг тус тус тодорхойлон, хамаарлыг Пирсоны корреляцийн аргаар тооцоолов. **Үр дүн**: Судалгаанд нийт 107 хугацаат цэргийн албан хаагч (ХЦАХ) хамрагдаж хасах шалгууруар 20 ХЦАХ хасагдаж нийт 87 хүн оролцсон. Судалгаанд хамрагдагсдын дундаж нас нь 19±1.18 жил байлаа. ХЦАХ-ын 17 (19.5%) хий давамгай шар хавсарсан, 8 (9.2%) хий давамгай бадган хавсарсан, 5 (5.7%) бадган давамгай хий хавсарсан, 7 (8.0%) бадган давамгай шар хавсарсан, 27 (31.0%) шар давамгай хий хавсарсан, 22 (25.3%) шар давамгай бадган хавсарсан өвөрчлөлтэй тодорхойлогдсон ба 1 (1.1%) хүн хурмал өвөрчлөлтэй тодорхойлов. Хамрагсдын стрессийн түвшин бага зэргийн стресстэй (0)-2 (2.29%), дундаас доогуур (1)-13 (14.94%), дундаас дээгүүр (2)-16 (18.39%), өндөр (3)-54 (62.06%), маш өндөр (4)-2 (2.29%) байсан ба шар давамгай хий хавсарсан өвөрчлөлтэй ХЦАХ-ын стрессийн түвшин өндөр байна. **Дүгнэлт:** 1. Дэвшилтэт технологийг практикт нэвтрүүлэх суурь баримжаа үзүүлэлт болох хугацаат цэргийн алба хаагчдын төрлөх өвөрмөц чанар нь хий шар, шар хий давамгай илэрсэн (31%), сэтгэл зүйн онцлогийн үзүүлэлтэд шар хий хавсарсан өвөрчлөл дийлэнх хувийг эзэлж байна. (88.2%) 2. Хий шар хавсарсан өвөрчлөлтэй хамрагдагсдын хөлийн булчин, гарын атгалтын хүч тус тус урвуу хамааралтай, шар бадган хавсарсан махбодтой хамрагдагсад статистик үнэн магадтай байна. (P=0.00)

Үндэслэл: Уламжлалт анагаах ухааны хий шар, бадганы сургаал нь хүний бие, хэл, сэтгэлийг нэгдмэл тогтолцоонд авч үздэг бөгөөд бие махбод эрүүл орших, өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчлөх, өвчнийг оношлох, эмчлэх аргыг онол арга зүйн хүрээнд цогц байдлаар авч үзэх үндэслэл болдог[1]. Хувь хүний төрөлх өвөрмөц чанар, сэтгэхүйн урвалж чанарын онцлогууд нь өөр хоорондоо салшгүй холбоотой бөгөөд тэдгээрийг хамтад нь цогц байдлаар судлах хэрэгтэй юм. Ийм учраас хүнийг өвчлөхөөс өмнө урьдчилан сэргийлэх, өвчнийг бус өвчтөнийг эмчлэх зарчим байх бөгөөд эдгээрийг хэрэгжүүлэхэд хувь хүний бие махбодын өвөрчлөлийг харгалзан үзэх шаардлагатай байдаг.[2] Нөгөө талаар өнөөдөр ДЭМБ (WHO) UNIVERSAL COVERAGE буюу бүх нийтийн эрүүл мэндийн тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр бодлого гаргаж түүнийг хэрэгжүүлж ажиллах тал дээр анхаарч байна. Өөрөөр хэлбэл хувь хүний эрүүл мэндийн системийг тогтолцоогоор авч үзэх, цаашлаад хүн бүрд нийцүүлэн оношилгоо эмчилгээний цогц нэгдмэл байдлыг хангахаар ажиллаж байгаа юм[3]. Түүнчлэн XXI зуун бүхэлдээ дижитал орон зайд шилжээд байгаа энэ цахим системийн эрэн үед уламжлалт анагаах ухааны зарим боломжит хэрэглэгдэхүүнийг дижитал системд нэвтрүүлэх, түүнийг хэрэглээ болох талаас нь уламжлалт анагаах ухааны системтэй орон бүр туйлын онцгой анхаарч ажиллаж эхлээд байна. Тухайлбал: БНХАУ, БНСУ, Энэтхэг, Япон зэрэг улс орнууд өөрсдийн уламжлалт анагаах ухааны хувь хүний өвөрмөц чанарыг тодорхойлох программ зохион бүтээж түүнийг эмнэлэг төдийгүй нийт иргэдийн хүрээнд ашиглуулж, түүгээр дамжуулан хувь хүн бүрд чиглэсэн эмчилгээний хийгдэж цаашлаад өвчнөөс урьдчилан сэргийлэх өргөн боломжуудыг цар хүрээгээр нь бий болгож байгаа нь эмнэлзүйн өндөр ач холбогдолтой байгаа юм. Тиймээс энэ чиглэлээр бусад орнуудын туршлагыг судалж Уламжлалт анагаах ухааны хувь хүний өвөрмөц чанар тодорхойлох цахим, дижитал буюу ARTIFICIAL INTELLIGENCE (AI) орон зайг үүсгэж ард иргэдэд чиглэсэн уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг илүү хялбаршуулах, Уламжлалт анагаах ухааны нэгдсэн мэдээллийн системийг бүрдүүлэхэд ач холбогдолтой юм. Сүүлийн жилүүдэд цэргийн албa хашиж буй эрэгтэйчүүдийн бие физиологийн онцлог, бие бялдар, сэтгэл санааны түвшин нь ялгаатай байгаа бөгөөд энэхүү онцлогоос шалтгаалж ачаалал даах чадвар нь харилцан адилгүй талаар цөөнгүй судалгаанд дурьдсан байна. Энэ тал дээр уламжлалт анагаах ухааны хувь хүний төрөлх өвөрмөц чанар тодорхойлох аргаар цэргийн албa хашиж буй эрэгтэйчүүдийн дунд судалгааг хийснээр тэдний бие физиологид тохирсон ачаалал, дасгал сургуулилтыг хувь хүн бүрд тааруулах цаашлаад эрүүл мэндтэй холбоотой гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой зэрэг нь энэхүү судалгааг хийх үндэслэл боллоо.

Зорилго: Хугацаат цэргийн албан хаагчдын төрөлх өвөрмөц чанарыг цахим өгөгдөлд суурилан тодорхойлж, бие физиологийн зарим үзүүлэлттэй харьцуулах.

Зорилт:

1. Хугацаат цэргийн албa хаагчдын хувь хүний төрөлх өвөрмөц чанар цахим өгөгдөл ашиглан тодорхойлох.
2. Цэргийн албa хашиж буй эрэгтэйчүүдийн төрөлх өвөрмөц чанар, сэтгэл түгшилт болон бие физиологийн хөгжил хоорондын хамаарлыг тогтоох.

Арга, аргачлал: Бид энэхүү судалгааг АШУҮИС, Монгол уламжлалт анагаах ухааны хүрээлэн, Монгол анагаах ухааны олон улсын сургууль, Зэвсэгт хүчний дугаар ангийг түшиглэн судалгааг нэг агшингийн болон эмнэлзүйн ажиглалтын загвараар хийж гүйцэтгэсэн. Хувь хүний төрөлх өвөрмөц чанарыг судлаас Б.Дагвацэрэн (2003) нарын аргаар 19 зүйлийн 44 өгөгдөлтэй цахим системээр тодорхойлж, бие бялдар физиологийн үзүүлэлт (булчингийн масс, гарын атгалтын хүч, хөлийн булчингийн хүч)-ийг Tanita DC-430 төхөөрөмжөөр, стрессийн түвшнийг Tailor (2010) нарын асуумжаар тус тус тодорхойлж хувь хүний төрөлх өвөрмөц чанартай харьцууллаа. Судалгааны ажлын үр дүнгийн тоон мэдээллийг боловсруулахдаа Microsoft Excel, SPSS26.0 (IBM software, Inc. USA) программуудыг ашиглан, дундаж утга, стандарт хазайлт, стандарт үзүүлэлтүүдийг тус тус тодорхойлон, хамаарлыг Пирсоны корреляцийн аргаар тооцоолов. АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны 2023 оны 12 сарын 15-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж судалгааг эхлүүлэх ёс зүйн зөвшөөрөл авж судалгааг хийж гүйцэтгэсэн. (Протокол №2023/3-10)

Үр дүн: Судалгаанд нийт 107 хугацаат цэргийн албан хаагч (ХЦАХ) хамрагдаж хасах шалгууруар 20 ХЦАХ хасагдаж нийт 87 хүн судалгаанд хамрагдсан. Судалгаанд хамрагдагсдын дундаж нас 19±1 байлаа. ХЦАХ-ын өвөрчлөлийн байдлыг авч үзвэл 17 (19.5%) хий давамгай шар хавсарсан, 8 (9.2%) хий давамгай бадган хавсарсан, 5 (5.7%) бадган давамгай хий хавсарсан, 7 (8.0%) бадган давамгай шар хавсарсан, 27 (31.0%) шар давамгай хий хавсарсан, 22 (25.3%) шар давамгай бадган хавсарсан өвөрчлөлтэй тодорхойлогдсон ба 1 (1.1%) хүн хурмал өвөрчлөлтэй тодорхойлов. Судалгаанд хамрагсдын стрессийн түвшин бага зэргийн стресстэй (0)-2 (2.29%), дундаас доогуур (1) 13 (14.94%), дундаас дээгүүр (2)-1 (18.39%), өндөр (3)-54 (62.06%), маш өндөр (4)-2 (2.29%) байсан ба шар давамгай хий хавсарсан өвөрчлөлтэй ХЦАХ-ын стрессийн төвшин өндөр байна.

Хүснэгт 1. Стрессийн түвшинг төрөлх өвөрмөц чанартай харьцуулсан байдал

Өвөрчлөл	Стрессийн түвшин				
	0	1	2	3	4
Хий+Шар	0 (0.0)	3 (17.6)	0 (0.0)	12 (70.6)	2 (11.8)
Хий+Бадган	0 (0.0)	1 (5.9)	1 (5.9)	6 (35.3)	0 (0.0)
Бадган+Хий	0(0.0)	0 (0.0)	2 (11.8)	3 (17.6)	0 (0.0)
Бадган+Шар	1 (5.9)	1 (5.9)	1 (5.9)	4 (23.5)	0 (0.0)
Шар+Хий	0 (0.0)	6 (35.3)	6 (35.3)	15 (88.2)	0 (0.0)
Шар+Бадган	1 (5.9)	2 (11.8)	6 (35.3)	13 (76.5)	0 (0.0)
Хурмал	0 (0.0)	0 (0.0)	0 (0.0)	1 (5.9)	0 (0.0)
Нийт	2 (2.29%)	13 (14.94%)	16 (18.39%)	54 (62.06%)	2 (2.29%)

Танита аппаратаар тодорхойлсон бие бялдар физиологийн үзүүлэлтүүд нь хоорондоо хүчтэй хамааралтай байсан. Ялангуяа дотор эрхтний өөхлөлтийн түвшин, бие дэх усны хэмжээ нь БЖИ-тэй шууд хамааралтай (p=0.000) байсан бол хөлийн булчингийн хүч нь БЖИ-тэй хүчтэй урвуу хамааралтай (p=-0.000) байлаа.

Хүснэгт 2. Бие физиологийн үнэлгээ

Үзүүлэлт	Тоо	Хамгийн бага утга	Хамгийн их утга	Дундаж	СХ
Нас	87	18	23	19.17	±1.183
Өндөр	87	171	193	184.34	±4.128
Өөхгүй биеийн масс (кг)	87	51.2	81.8	60.61	±5.3475
Булчин масс (кг)	87	48.5	77.6	57.508	±5.1349
Бие дэх усны хэмжээ (кг)	87	31.8	62.4	39.462	±5.4484
Ясны масс (кг)	87	2.7	5	3.169	±0.3279
Дотор эрхтний өөхлөлтийн түвшин	87	1	15	6.67	±2.684
Хөлийн булчингийн хүч оноо	87	78	150	93.57	±9.033
Жин	87	62.4	124.5	76.9	±10.2894
Атгалтын хүч (баруун)	87	30	72	47.43	±8.654
Атгалтын хүч (зүүн)	87	30	68	47.2	±8.85

Гарын атгалтын хүч нь хий дийлэнх хүмүүсийнх хүчтэй урвуу хамааралтай (p=-0.000) байсан бол бадгана дийлэнх хүмүүсийнх шууд хамааралтай (p=0.000) байсан.



Зураг 1. Гарын атгалтын хүч, хөлийн булчингийн хүчийг төрөлх өвөрмөц чанартай харьцуулсан дүн.

Хэлцэмж: Хугацаат цэргийн алба хаагчид болон ард иргэд өөрсдийн төрөлх өвөрмөц чанарыг тогтоож, өвчнөөс урьдчилан сэргийлэх идээ ундаа, явдал мөрийн зөвлөгөө хялбар аргаар авах практикийн чухал ач холбогдолтой учраас хэлцэмжид арга зүй нь ижил төстэй зарчмаар хийгдсэн эрдэмтдийн судалгааны ажилтай өөрсдийн судалгааг харьцууллаа.

Манай улсад хувь хүний төрөлх өвөрмөц чанарыг тодорхойлсон Б.Цэрэнцоо нарын (2010) оны судалгаанд уламжлалт анагаах ухааны бие махбодын

өвөрчлөлийг антропометрийн хэмжилт болон сэтгэл судлалын зарим аргаар харьцуулан судлахад хий шар хавсарсан өвөрчлөлтэй хүмүүс хамгийн их байсан бөгөөд хүн өндөр байх тусам бадгана, намхан болох тусам хий давамгайлж сэтгэл түгшилт ихсэх тусам хий, багасах тусам бадгана, шар дундаж байгааг тогтоосон. Бидний судалгаанд шар, хий хавсарсан хүмүүс дийлэнх байсан бөгөөд шар хий хавсарсан хүмүүст стрессийн түвшин нэмэгдэж байсан нь ялгаатай байсан.[1]

Судлаач Ө.Батчимэг (2003) нарын өвчнөөс сэргийлэх оношлох уламжлалт анагаах ухааны үндсэн зарчмын логик арга зүйн судалгаагаар хий шар хосолмол өвөрчлөлтэй хүмүүс 57% буюу их байсан. Энэ судалгаанд оюутан цэрэг, тамирчид, харьцангуй эрүүл 20-29 насны хүмүүс байсан нь бидний судалгаанд мөн 18-23 насны харьцангуй эрүүл хугацаат цэргийн албан хаагчид хамрагдсанаас шар дийлэнх өвөрчлөлтэй байсан нь дүйж байлаа.[8]

Онолын хувьд биеийн бэлгэ чанар гэдэг нь хий, шар бадганы мөн чанарыг тодорхойлох 20 бэлгэ чанараас хамаарч хорлогч, хорлогдогч, гурван хир хоорондоо харилцан түшиглэж тэнцвэртэй оршдог болохыг тэмдэглэсэн байдаг. Хүүхэд насанд шороо усан махбод дэлгэрч шим тэжээлийг их хэмжээгээр шингээн авч өсөн бойжих шат болохоор бадган дийлэнх байна. Идэр насанд тамир хүч хамгаас төгөлдөржин, галын илч хамгийн бадрангуй байх үе шат болохоор шар дийлэнх байна. Хөгшин үед галын илч аажмаар бууран доройтож, биеийн шим нь хорогдож байх үе шат бөгөөд хий дийлэнх байна. Бидний судалгаанд хий шар хавсарсан өвөрчлөлтэй хүмүүс хөлийн булчингийн хүч, гарын атгалтын хүчтэй урвуу хамааралтай байгаа нь хийн хөнгөн, хөлбөрөнги, нарийн, ширүүн, сэрүүн шарын хөнгөн бэлгэ чанартай дүйж болохоор байна. Шар дийлэнх бадган дийлэнх махбодтой хүмүүс эерэг хамааралтай байгаа нь шарын хурц, халуун, хөнгөн бадганы зөөлөн бэлгэ чанартай, шар бадган болон бадган хий махбодтой хүмүүс хөлийн булчингийн хүчтэй урвуу хамааралтай байгаа нь шарын тослог, нойтон бадганы хүнд, батлаг, наалдамхай, моxдог бэлгэ чанартай дүйж болохоор байна[20,21].

Дүгнэлт:

1. Дэвшилтэт технологийг практикт нэвтрүүлэх суурь баримжаа үзүүлэлт болох хугацаат цэргийн алба хаагчдын төрлөх өвөрмөц чанар нь хий шар, шар хий давамгай илэрсэн (31%), сэтгэл зүйн онцлогийн үзүүлэлтэд шар хий хавсарсан өвөрчлөл дийлэнх хувийг эзэлж байна. (88.2%)
2. Хий шар хавсарсан өвөрчлөлтэй хамрагдагсдын хөлийн булчин, гарын атгалтын хүч тус тус урвуу хамааралтай, шар бадган хавсарсан махбодтой хамрагдагсад статистик үнэн магадтай байна. (P=0.00)

Ном зүй:

1. *Б.Цэрэнцоо, Уламжлалт анагаах ухааны бие махбодын өвөрчлөлийг антропометрийн хэмжилт болон сэтгэл судлалын зарим аргаар харьцуулан судлах асуудал, АУ-ны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл Улаанбаатар: Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль; 2010*
2. *Анагаах Ухааны Дөрвөн Үндэс. Улаанбаатар: 1991, Биеийн бэлгэ чанарын бүлэг.*
3. *Universal health coverage (UHC) Universal health coverage (UHC) (who.int)*
4. *С.Цэндсүрэн, Хувь хүний шинж төрх ба захын цусны дархлааны үзүүлэлтийн хоорондын холбоог цусны донoруудад судалсан дүн, АУ-ны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл Улаанбаатар: Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний их сургууль; 2022*
5. *С.Сээсрэгдорж, С.Өлзийбаатар, Монголын Уламжлалт Анагаах Ухааны Хүний Төрөлх Өвөрмөц Чанарын Шинжлэл Улаанбаатар: 2021 61-65х*
6. *С.Өлзийбаатар, Хүний төрөлх өвөрмөц чанарын харьцуулсан судалгаа, АУ-ны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл; Улаанбаатар: 2022*
7. *Arttificial intelligence Artificial intelligence - Wikipedia*
8. *Ө.Батчимэг, Б.Дагвацэрэн. Өвчнөөс сэргийлэх, оношлох уламжлалт анагаах ухааны үндсэн зарчмын логик, арга зүйн судалгаа, АУ-ны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл Улаанбаатар: 2003*
9. *Ш.Болд, Монголын уламжлалт анагаах ухаан: гүн ухаан онол, эрүүл биеийн судлал: Адмон. Улаанбаатар; 2012*
10. *Б.Дагвацэрэн, Ө.Батчимэг, Т.Варламова, Г.Наранцэцэг, Өвчнөөс сэргийлэх уламжлалт анагаах ухааны ёс: Интерпресс. Улаанбаатар; 2003.*
11. *Chung SK, Cha S, Lee EY, Park JH. The five elements of the cell. Integrative Medicine Research. 2017;6:452-456. Адмон. Улаанбаатар; 2012.*
12. *Б.Дагвацэрэн, Монгол, Төвд анагаах ухааны онол арга зүйн үндэс : жам ёсны тогтолцооны төгс зохирол ба тогтолцооны ерөнхий онол. Улаанбаатар: Цэргийн хэвлэлийн "Шувуун саарал" компани;1996.*
13. *Grant B, Moving Towards Individualized Medicine For All. LabX Media Group. The Scientist. July15, 2019:https://www.the-scientist.com/editorial/monogrammed-medicine-66089*
14. *Health across the lifespan. The World Health Report 1998 Life in the 21st century A Vision for all Report of Director-General World Health Organization, Geneva, 1998.61-113. www.who.int/whr/1998/en/whr98_dgmessage.pdf?ua=1.*
15. *Wheeler JB, Rueschhoff A. Improving Women's Health Opportunities and Challenges in Health Reform. National Conference of State Legislatures. 2012:https://www.ncsl.org/research/health/improving-womens-health-opportunities.aspx.*
16. *Anthropometric Reference Data for Children and Adults: United States, 2007–2010. U.S.Report issued by Department of Health and Human Services, Centers for Disease Control and Prevention and National Center for Health Statistics. . Vital Health Statistics. 2012;11:3-4.*
17. *www.cdc.gov/nchs/data/series/sr_11/sr11_252.pdf.*
18. *Obesity.WHOHealthtopics.2020:https://www.who.int/health-topics/obesity#tab=tab_1.*
19. *Seidell JC, Halbersdadt J, The occurrence of obesity in an individual or in populations is aresult of combinations of factors at multiple levels of influence. Ann Nutr Metab. 2015;66:7-12.doi.org/10.1159/000375143.*
20. *Stevens GA, Singh G, Lu Y, Danaei G, Lin JK, et al. Global Burden of Metabolic Risk Factors of Chronic Diseases Collaborating Group (Body Mass Index). National, regional, and global trends in adult overweight and obesity prevalences. Population Health Metrics. 2012;10:doi:10.1186/1478-7954-10-22*
21. *С.Сээсрэгдорж Д.Цэрэндавга, Монгол анагаах ухааны өвчнийг шинжилж нотлохуйн нэгдмэл толь Улаанбаатар:2023*
22. *Т.Алимаа, Ч. Батнайрамдал, С. Доржбат, Түүх ба үндсэн онол Улаанбаатар:2020*

The study of conscript's personal characteristics with some physical measurements and stress level

Lodoisambuu B[1], Delgerekhzaya E[1], Batbaatar B[4] Tserenwandan Kh[5]
Tsend-Ayush D[1], Tsendsuren S[2], Dorjbat S[3]

[1]ISMM, MNUMS
[2]CSGE, Graduate School, MNUMS
[3]Institute of Mongolian Traditional Medicine, MNUMS
[4]Central Military Hospital
[5]School of Bio Medicine, MNUMS
E-mail: Lodoisambuu@mnums.edu.mn, Tel: +976-95697363

Background: The theory of RLUNG, MKHRIS, and BADGAN in traditional medicine explains the human body, speech, and soul in a unified manner, and is the basis for a comprehensive consideration of the healthy existence of the body, disease prevention, disease diagnosis, and treatment within the framework of theory and methodology.[1] In other words, we are working to consider the individual's healthy body as a whole unit and further to ensure the comprehensive integration of diagnosis and treatment for each person.[3] In the Sustainable Development Goal of Mongolia-2030, within the framework of the government policy to increase the average life expectancy of Mongolian people, especially within the national policy of increasing the average life expectancy of Mongolian men, we assume it is important to determine the personality traits of individuals among relatively healthy military age men in the future as part of social responsibility to increase the average life expectancy of Mongolian men.

Aim: To determine the inherent personality traits of the individual based on electronic data and compare them with psychological characteristics.

Materials and Methods: We conducted this study using a single-moment and clinical observation model based on MNUMS, International School of Mongolian Medicine, and Armed Forces Department No.

Results: A total of 107 servicemen participated in the study, 20 of them were excluded based on the exclusion criteria, and a total of 87 people were included. The average age of the respondents was 19 ± 1.18.

Among them, 17 (19.5%) had rlung-dominant mkhris combined, 8 (9.2%) were identified as rlung-dominant badgan combined, 5 (5.7%) identified as a badgan-dominant rlung combined, 7 (8.0%) identified as a badgan-dominant mkhris combined, 27 (31.0%) identified as mkhris-dominant rlung combined, 22 (25.3%) identified as mkhris-dominant badgan combined, and 1 (1.1%) person was identified as all three combined personality traits, respectively.

The stress levels of the participants were mildly stressful (0)-2 (2.29%), below average (1)-13 (14.94%), above average (2)-16 (18.39%), high (3)-54 (62.06%), was very high (4)-2 (2.29%) and the servicemen identified as mkhris-dominant rlung combined had high levels of stress.

Conclusions:

1. The genetic characteristics of conscripts, which are the fundamental indicators of the introduction of advanced technology into practice, were found to be predominantly rlung-mkhris dominant and mkhris-rlung dominant (31%), and the majority of psychological characteristic indicators were combined mkhris-rlung (88.2%).
2. The leg muscles and hand strength of subjects with combined rlung-mkhris are inversely related, and it is statistically significant for subjects with mkhris-bad kan combined characteristics. (P=0.00)

Keywords: Inherent personality traits, Temporary military servicemen (servicemen), Rlung, Mkhris, Badgan